

**ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН 2021-2024 ОНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Бодлогын баримт бичигт тусгагдсан, үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт	Стратеги /арга зам/	Шалгуур үзүүлэлт /хэмжүүр/	Зорилтот түвшин	Биелэлт	Хэрэгжилтийн хувь
			2021-2024		
ХУУЛЬ САХИУЛАХ САЛБАРЫН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ САЙЖРУУЛАН, БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫГ ДЭМЖИЖ, АЖИЛЛАХ НӨХЦӨЛИЙГ ДЭЭШЛҮҮЛЖ, МЭРГЭШСЭН ЧАДВАРЛАГ ХҮНИЙ НӨӨЦИЙГ БЭЛТГЭН ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫГ ХӨГЖҮҮЛНЭ. /“АЛСЫН ХАРАА-2050” БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ 7.4/					
НЭГ. ИХ СУРГУУЛИЙН ЗАСАГЛАЛЫГ САЙЖРУУЛАН, ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОЖ, МЕНЕЖМЕНТИЙН НЭГДСЭН ТОГТОЛЦООГ ТӨЛӨВШҮҮЛНЭ.					
ЗАСАГЛАЛЫГ САЙЖРУУЛАХ	1.1. Дотоод хэргийн их сургуулийн бүтэц зохион байгуулалтыг салбарын хөгжилтэй уялдуулан алба хаагчийн ажлын ачааллыг тэнцвэржүүлж үүрэг гүйцэтгэх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор шат дараатай арга хэмжээ авна.	Ажлын ачааллыг бууруулсан хувь	20	Их сургуулийн багш, албан хаагчдын ажлын ачааллыг тэнцвэржүүлэх зорилгоор Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны А/132 дугаар тушаалаар баталсан бүтэц, орон тоогоор 31 орон тоо, 2023 оны А/119 дүгээр тушаалаар баталсан бүтэц, орон тоогоор 12 орон тоо, 2024 оны А/102 дугаар тушаалаар баталсан бүтэц, орон тоогоор 25 орон тоо, нийт 68 орон тоог нэмэгдүүлсэн. Мөн Их сургуулийн ахлагч бүрэлдэхүүний нийгмийн баталгааг хангах, үүрэг гүйцэтгэх чадварыг нэмэгдүүлэх хүрээнд Их сургуулийн захирлын 2023 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн Б/480 дугаар тушаалаар ТТ-9-өөс ТТ-12 дугаар ангилал, зэрэглэлийн нийт 63 ахлагч бүрэлдэхүүний орон тооны цалингийн ангилал, зэрэглэлийг адилтгах бодлогыг хэрэгжүүлэн, ТТ-9 болгон адилтгасан.	100%
	1.2. “Дотоод хэргийн их сургуулийн хүний нөөцийн төлөвлөлт бодлогын баримт бичиг 2020-2024”-ийг хэрэгжүүлнэ.	Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	100	Их сургуулийн захирлын 2020 оны А/298 дугаар тушаалаар баталсан “Хүний нөөцийн бодлогын баримт бичиг”-ийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг жил бүр батлан төлөвлөгөөний хэрэгжилтийг 100% ханган ажилласан. Хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээнээс онцлог ажил, арга хэмжээг дурдвал: Тайлангийн хугацаанд Төрийн албаны тухай хуульд заасан шатлан дэвших, чадахуйн зарчим (мерит)-ыг хэрэгжүүлж, газрын даргын албан тушаалд 2, бүрэлдэхүүн сургууль, институтын захирлын албан тушаалд 6, албаны даргын албан тушаалд 7, тэнхимийн эрхлэгч, профессор, төвийн эрхлэгч, хэсгийн даргаар 24, дэд профессорын албан тушаалд 15, ахлах багшийн албан тушаалд 33, арга зүйчийн албан тушаалд 2, ахлах мэргэжилтний албан тушаалд 20, офицерын бүрэлдэхүүнд 33, нийт 142 албан хаагчийг дэвшүүлэн томилсон.	100%

	1.3. Клиник сургалтын орчныг бүрдүүлэх зорилгоор Дотоодын цэргийн анги байгуулна.	Байгуулсан ангийн тоо	1	Дотоодын цэргийн 804 дүгээр ангийн захидал, харилцааны дугаарыг “Дотоод хэргийн их сургууль”-д сэргээн олгуулах хүсэлтийг албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яам, Цагдаагийн ерөнхий газарт тус тус хүргүүлж, Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчийн 2022 оны н1А/16 тоот тушаалаар Дотоод хэргийн их сургуульд өмнө хэрэглэж байсан Дотоодын цэргийн 804 дүгээр ангийн захидал харилцааны дугаарыг сэргээн, үйл ажиллагааг явуулж байна.	100%
	1.4. Онцгой байдлын сургууль, Ахлагчийн сургууль болон зарим бүрэлдэхүүн сургуулийн статусыг харьяа сургууль болгон өөрчлөн зохион байгуулна.	Харьяа сургуулийн тоо	2	Монгол Улсын Засгийн газрын 2023 оны “Төрийн өмчийн зарим их сургуулийн харьяа ерөнхий боловсролын ахлах сургуулийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 307 дугаар тогтоолоор Дотоод хэргийн их сургуулийн дэргэдэх Ерөнхий боловсролын Ахлах сургуулийг Дотоод хэргийн их сургуулийн харьяа Ерөнхий боловсролын Ахлах сургууль болгон өөрчлөн зохион байгуулсан. Монгол Улсын Засгийн газрын 2024 оны “Ахлагчийн мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв”-ийг өөрчлөн зохион байгуулах тухай” 122 дугаар тогтоолоор Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийн харьяа Ахлагчийн мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийг Дотоод хэргийн их сургуулийн харьяа “Ахлагч” мэргэжлийн боловсролын сургууль болгон өөрчлөн зохион байгуулсан.	100%
	1.5. Их сургуулийн жендерийн дэд зөвлөлийн үйл ажиллагааг зохион байгуулна.	Төлөвлөгөө батлуулж, хэрэгжүүлсэн эсэх	100	Их сургуулийн захирлын 2022 оны А/104 дүгээр тушаалаар Дотоод хэргийн их сургуулийн Жендерийн дэд зөвлөлийг байгуулж, ажиллах журам, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг батлан, үйл ажиллагааг хагас, бүтэн жилээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд тайлагнан ажиллаж байна.	100%
ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ	1.6. Эрх зүйч, хууль сахиулагч бэлтгэх дээд боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааг зохицуулах тухайлсан хууль боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.	Хуулийг боловсруулж, батлуулсан эсэх	1	Дотоод хэргийн их сургуулийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд боловсруулан Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн. Хууль зүй, дотоод хэргийн яамны дэргэд ажлын хэсэг байгуулагдан, хуулийн төсөлтэй холбоотой харьцуулсан судалгааг хийж, бусад яамдаас санал авсан. Хуулийн төсөлд mofha.gov.mn хаягаар санал авч байна.	90%
	1.7. “Шинжлэх ухаан, инновацийн кластер” байгуулах хууль тогтоомжийг судалж, түүнд нийцүүлэн Их сургуулийн Шинжлэх ухаан, инновацийн кластер байгуулах эрх зүйн орчныг бүрдүүлнэ.	Боловсруулсан эрх зүйн актын тоо	1	Дотоод хэргийн их сургуулийн “Шинжлэх ухаан, инновацийн кластер” байгуулах эрх зүйн орчныг сайжруулах талаар Их сургуулийн захирлын 2024 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн А/130 тушаалаар ажлын хэсэг байгуулсан. Энэхүү ажлын хэсэг Эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажил гүйцэтгэх журам, Эрдэм шинжилгээ, инновацийн бүтээл, судлаачийг дэмжих, урамшуулах зэрэг нийт 6 журмыг шинэчлэн боловсруулж, батлуулан “Шинжлэх ухаан, инновацийн кластер” байгуулах эрх зүйн орчныг бүрдүүлээд байна.	90%

МЕНЕЖМЕНТИЙН НЭГДСЭН ТОГТОЛЦООГ ТӨЛӨВШҮҮЛЭХ	<p>1.8. Их сургуулийн үйл ажиллагаанд нэгдсэн менежментийн тогтолцоог нэвтрүүлнэ.</p>	<p>Нэвтрүүлсэн стандарт</p>	<p>6</p>	<p>Дотоод хэргийн их сургууль нь 2021-2024 онд үйл ажиллагаандаа олон улсын стандартуудыг үе шаттайгаар нэвтрүүлэх зорилтыг дэвшүүлэн ажилласан. Энэ хүрээнд 2021 онд ISO 9001:2015 Чанарын менежментийн тогтолцоо, ISO 21001:2018 Боловсролын байгууллагын менежментийн тогтолцоо, 2022 онд ISO 31000:2018 “Эрсдлийн менежмент-зарчим ба заавар” стандарт, 2023 онд ISO 45001:2018 “Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн тогтолцоо-шаардлага, хэрэглэх заавар” стандартыг тус тус амжилттай нэвтрүүлсэн.</p> <p>Байгууллагын менежментийн тогтолцоо шалгуур үзүүлэлттэй нийцэж байгааг тодорхойлох, хэрэглэгчийн болон холбогдох хууль эрх зүйн зохицуулалтын болон гэрээний шаардлагыг хангаж байгаа эсэхэд менежментийн тогтолцооны чадавхи, үр нөлөөтэй байдлыг үнэлэх, сайжруулах боломжуудыг тодорхойлох зорилгоор нэгдсэн менежментийн тогтолцоо, стандартын давтан баталгаажуулах аудитыг 2024 оны 06 дугаар сарын 10-наас 12-ны өдрүүдэд зохион байгуулж, ISO 9001:2015 Чанарын менежментийн тогтолцоо, ISO 21001:2018 Боловсролын байгууллагын менежментийн тогтолцооны олон улсын стандарт нэвтрүүлснийг давтан баталгаажуулсан гэрчилгээг 3 жилийн хугацаагаар олгосон.</p> <p>Мөн 2024 онд олон улсын ISO/IEC 27001:2022 Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоо, стандартыг нэвтрүүлэх зорилтын хүрээнд “ISOMiND” ХХК-тай хамтран “Зөрүүгийн шинжилгээ” хийх ажлыг 2024 оны 11 дүгээр сарын 05-11-ний хооронд зохион байгуулж, 23 албан хаагчийг дотоод аудиторын сургалтад хамруулсан. Цаашид 2025 оны 01 дүгээр сараас эхлэн тус стандартыг нэвтрүүлэх зөвлөх үйлчилгээг эхлүүлэхээр бэлтгэл ханган ажиллаж байна.</p> <p>2025 оноос эхлэн нэгдсэн менежментийн тогтолцоог нэгдмэл тогтолцоогоор удирдаж, хянахаар өөрчлөлтийг төлөвлөөд байна.</p>	<p>90%</p>
	<p>1.9. Гадаадын ижил төрлийн их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагатай хамтын ажиллагааг өргөжүүлнэ.</p>	<p>Нэмж байгуулах санамж бичгийн тоо</p>	<p>13</p>	<p>Их сургуулийн гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлж хөгжүүлэх хүрээнд гадаадын 13 ижил төрлийн их дээд сургууль, байгууллагатай хамтран ажиллах санамж бичиг, гэрээ байгуулсан. Үүнд: 2022 онд БНСУ-ын Вүүсок их сургууль, Чамуван эмнэлэг, Эль эмнэлэг, ОХУ-ын Дотоод хэргийн яамны харья Волгоградын академи, 2023 онд Унгар Улсын Нийтийн удирдлагын их сургууль, БНСУ-ын Үндэсний цагдаагийн их сургууль, АРЕХ Олон улсын байгууллага, Кайст их сургууль, Чунбук их сургууль, Алс Дорнодын их сургуультай тус тус хамтран ажиллах санамж бичиг байгуулсан, мөн БНСУ-ын Вүүсок их сургуультай солилцооны хөтөлбөрийн гэрээ, 2024 онд БНСУ-ын Үсанг их сургууль, Гёнги их сургууль, БНФУ-ын “Аз жаргалтайгаар суралцъя” академи, ОХУ-ын Доржи Банзаровын</p>	<p>100%</p>

				нэрэмжит Буриад Улсын их сургуультай тус тус хамтран ажиллах санамж бичиг, гэрээ байгуулсан.	
	1.10. Үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, чанарын үнэлгээ, удирдлагын дүн шинжилгээ хийх тогтолцоог бэхжүүлэх, эрсдэлд суурилсан дотоод аудит хийж, үр дүнг тооцон, үйл ажиллагааг сайжруулна.	Сэтгэл ханамжийн хувь	90	Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2020 оны “Дотоод хэргийн их сургуулийн бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай” А/133 тоот тушаалаар “Чанарын баталгаажуулалтын төв”-ийг байгуулж, эрхлэгч, 2 ахлах мэргэжилтэн, нийт 3 албан хаагчийн бүрэлдэхүүнтэйгээр үүсгэн байгуулж, чанарын үнэлгээ, удирдлагын дүн шинжилгээ хийх тогтолцоог бэхжүүлэн ажиллаж байна. Их сургуулийн үйл ажиллагаа, бодлогын баримт бичигт үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, чанарын үнэлгээ, эрсдэлд суурилсан дотоод аудитыг бил бүр зохион байгуулж, үр дүнг Хууль зүй, дотоод хэргийн яаманд тайлагнан үнэлүүлж, агентлаг байгууллагын хэмжээнд эхний байруудад шалгаран ажилласан. 2021-2024 онд Нэгдсэн менежментийн тогтолцоо (ISO 9001:2015, ISO 21001:2018)-ны хүрээнд бүрэлдэхүүн сургууль бүтцийн нэгжүүдэд нийт 5 удаагийн дотоод аудитыг зохион байгуулж, үр дүнг удирдлагын дүн шинжилгээний хуралд тухай бүр танилцуулж, үйл ажиллагаандаа байнгын сайжруулалт хийн ажилласан.	100%
	1.11. Дотоод хэргийн их сургуулийн эрдэм шинжилгээ, судалгааны ажлын санхүүжилтийг нэмэгдүүлж, судалгаа боловсруулалтын ажлыг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлж, эдийн засагт үзүүлэх үр нөлөөг дээшлүүлнэ.	Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын зардлын ДХИС-ийн жилийн төсөвт эзлэх хувь	2	Их сургуулийн төсөв 2021 оноос хойш 50 хувиар нэмэгдсэнтэй холбогдуулан эрдэм шинжилгээ, судалгааны ажилд шаардагдах зардлын санхүүжилтийг 2021-2024 онд жил бүр 0.5 хувиар нэмэгдүүлсэн. Тухайлбал, 2021 онд Их сургуулийн эрдэм шинжилгээ судалгааны ажилд 25.6 сая төгрөгийг зарцуулсан бол 2024 онд 503.8 сая төгрөгийг зарцуулсан байна.	100%
	1.12. Их сургуулийн PR-ийн менежментийг сайжруулж, мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллана.	Хэрэгжилтийн хувь	100	Их сургуулийн PR-ийн менежментийг сайжруулах хүрээнд “Эрдмийн далай” сониныг 2021-2024 онд цахимаар 8 удаа, хэвлэмэл байдлаар 22 удаа эрхлэн гаргаж, нийтийн хүртээл болгосон. Их сургуулийн үйл ажиллагааг сурталчилах чиглэлээр “ДХИС ЦАХИМ ТВ ҮЗҮҮЛЖ БАЙНА” видео контентыг бэлтгэж, “Ярилцлагын цаг”, “Эрдэм студийс шууд дамжуулан үзүүлж байна”, “Сонсогч ярьж байна”, “Төгсөгч ярьж байна”, “U vlog” “Эрдэм” подкаст зэрэг 10 гаруй буланг шинээр нээж, Их сургуулийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчилан ажиллаж байна. Их сургуулийн http://www.uia.gov.mn/ хуудсанд 1000 гаруй мэдээ, мэдээлэл, “Дотоод хэргийн их сургууль” фэйсбүүк хуудсанд 2100 гаруй мэдээ, мэдээлэл, 500 гаруй видео контент бэлтгэн байршуулсан. Одоогоор фэйсбүүк хуудасны хандалт 138,723-д хүрсэн.	100%

				2022-2023 оны хичээлийн жилээс Их сургуулийн “Эрдэм” студийн дэргэд “Сонсогч, сурвалжлагч” клуб байгуулан 18 гишүүдтэй өдөр тутмын үйл ажиллагаа болон тэмдэглэлт үйл явдлыг сурвалжилан 200 гаруй мэдээ, мэдээллийг бэлтгэн нийтийн хүртээл болгосон. Мөн Их сургуулийн үйл ажиллагааг өдөр тутмын 15 сайтад 56 мэдээ мэдээлэл, 4 телевизэд 13 мэдээ мэдээлэл, өдөр тутмын 3 сонинд 4 удаагийн мэдээ нийтлүүлж, олон нийтэд хүргэсэн. Их сургуулийн түүхт 90 жилийн ойг тохиолдуулан WSUP студитэй хамтран “Сонсогчид” 10 ангит уран сайхны кино, “Тусгаар тогтнолын дархлааг тогтоогчид” баримтат киног тус тус хамтран бүтээж, нийтийн хүртээл болгосон.	
	1.13. Их сургуулийн Brandbook, сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын стандартыг шинэчлэн боловсруулж, мөрдүүлнэ.	Шинэчлэн боловсруулсан стандартын тоо	2	Их сургуулийн захирлын 2022 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн А/559 дүгээр тушаалаар Их сургуулийн брендбүүкийг шинэчлэн боловсруулах үүрэг бүхий ажлыг хэсгийг байгуулсан. Ажлын хэсгээс Их сургуулийн брендбүүкийг шинэчилж, тухай бүр өөрчлөлтийг тусгаж ажилласан. Их сургуулийн захирлын тушаалаар баталсан бүрэлдэхүүн болон харьяа сургууль, институт, төвийн бэлгэдэл, далбаа хэрэглэх журам, бэлгэдэл, далбааны загварын дагуу Их сургуулийн брэндбүүкт нэмэлт, өөрчлөлт оруулж, 28 хувь хэвлэн бүтцийн нэгжүүдэд хүргүүлж, үйл ажиллагаанд ашиглуулж байна. Их сургуулийн эрдэм шинжилгээ, судалгааны ажлын стандартыг шинэчлэн боловсруулж батлуулан, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.	100%
	1.14. Их сургуулийн байгууллагын магадлан итгэмжлэлийн шалгуур, шаардлагын хүрээнд ахиц дэвшлийг тайлагнах ажлыг зохион байгуулна.	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	100	Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний Зөвлөлийн Дээд боловсролын магадлан итгэмжлэх комиссын 2021 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 08 тоот тогтоолоор Их сургуулийг 5 жилийн хугацаатай магадлан итгэмжилсэн. Тус тогтоолын хүрээнд 2021 онд 18 зөвлөмж өгч, “Зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө” гарган хэрэгжилтийг ханган ажилласан. Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний Зөвлөлөөс томилогдсон шинжээчийн баг 2024 оны 06 дугаар сарын 27-ны өдөр Их сургуульд ажиллаж, магадлан итгэмжлэлийн ахиц дэвшлийн тайланд үнэлгээ өгч, 12 зөвлөмжийг ирүүлсний дагуу хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган ажилласан.	100%
ХОЁР. ИХ СУРГУУЛИЙН ХҮНИЙ НӨӨЦИЙГ НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫГ УХАМСАРЛАГЧ, ШИНЭ МЭДЛЭГ БҮТЭЭГЧ ШИЛДЭГ БАГШ, СУДЛААЧДААР БҮРДҮҮЛНЭ.					
НИЙГЭМД ЧИГЛЭСЭН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ	2.1. Гадаадын ижил төрлийн их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагатай хамтын ажиллагааны хүрээнд	Солилцоонд хамрагдсан албан хаагч,	16/30	Хэрэгжилтийн хугацаанд нийт 57 албан хаагч, 124 сонсогч суралцагчдыг солилцооны хөтөлбөрт хамруулсан. Үүнд, багш солилцооны хөтөлбөрийн хүрээнд 2022-2023 онд БНСУ-ын Чангшин их сургуульд 1 албан хаагчийг зочин багшаар ажиллуулсан. 2023-	100%

	<p>судлаач, багш, суралцагч солилцооны хөтөлбөр хэрэгжүүлнэ.</p>	<p>суралцагчийн тоо</p>		<p>2024 онд БНСУ-ын Эль эмнэлэгтэй байгуулсан санамж бичгийн хүрээнд зочин эмчээр ажиллан, эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх сургалтад Их сургуулийн 5 албан хаагч, АНУ-ын Миссури мужийн их сургуулийн англи хэлний сургалтад Их сургуулийн 14 албан хаагч, БНТУ-ын Үндэсний цагдаагийн академитай хамтран хэрэгжүүлсэн “Шилдэг туршлага, мэдээлэл солилцох” солилцооны хөтөлбөрт 3 албан хаагч, БНСУ-ын Вүүсок их сургуулиас зохион байгуулсан “Багш нарт зориулсан зуны сургалт” солилцооны хөтөлбөрт Их сургуулийн 25 албан хаагч, ОХУ-ын Холбооны аюулгүй байдлын албанаас зохион байгуулсан сургалтад 1 албан хаагч, БНФУ-ын Сэбүгийн олон улсын академи, “Аз жаргалтайгаар суралцъя” академийн англи хэлний сургалтад 8 албан хаагчийг тус тус хамруулсан.</p> <p>Мөн 2023-2024 оны хичээлийн жилд АНУ-ын Фулбрайтын Англи хэлний туслах багшийн хөтөлбөрт хамрагдан, Англи хэлний 2 туслах багшийг, 2024-2025 оны хичээлийн жилд АНУ-ын Феллов хөтөлбөрт хамрагдаж, Англи хэлний 1 багшийг, АНУ-ын 1 зочин багшийг Их сургуульд тус тус ажиллуулж байна.</p> <p>Сонсогч, оюутан солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэх хүрээнд 2021-2022 онд БНСУ-ын Чангшин их сургуультай хамтран хэрэгжүүлж буй 2+2 хос диплом олгох хөтөлбөрт 98 сонсогч, суралцагч, БНСУ-ын Тэнгисийн цэргийн академийн “Ерөнхий цэргийн тактик” мэргэжлээр 1 сонсогч, 2023 онд БНСУ-ын Вүүсок их сургуульд солилцооны хөтөлбөрийн хүрээнд 4 суралцагч, 2023-2024 онд Энэтхэгийн соёлын харилцааны зөвлөл (ЭСХЗ)-ийн ICCR тэтгэлэгт хөтөлбөрийн хамрагдан БНЭУ-ын Шинжлэн магадлахуйн үндэсний их сургуульд 15 сонсогч, 2024 онд БНСВУ-ын Нийгмийн аюулгүй байдлын яамны харьяа Ардын цагдаагийн академитай хамтран хэрэгжүүлж буй солилцооны хөтөлбөрт 3 сонсогч, БНХАУ-ын Ардын нийгмийг аюулаас хамгаалах их сургуультай хамтран хэрэгжүүлж буй солилцооны хөтөлбөрт 3 сонсогчийг тус тус хамруулан суралцуулж байна. Мөн БНСВУ-ын Ардын цагдаагийн академиас 3 сонсогч Дотоод хэргийн их сургуульд суралцаж байна.</p>	
	<p>2.2. Иргэд, байгууллагуудад хууль зүйн туслалцаа үзүүлэх үйлчилгээг үзүүлнэ.</p>	<p>Үйлчилгээ үзүүлэх төвтэй эсэх</p>	<p>1</p>	<p>Их сургуулийн дэргэдэх “Хууль зүйн туслалцааны төв”-ийг шалган нэвтрүүлэх байрны дэргэд байгуулан, БЗД-ийн 8 дугаар хорооны иргэд болон эрх зүйн туслалцааг авах хүсэлтэй 100 гаруй иргэнд цахимаар болон биечлэн зөвлөгөө өгч ажилласан.</p>	<p>100%</p>
	<p>2.3. Цэргийн байнгын тэтгэвэрт гарах алба хаагчдад зориулсан сургалтын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.</p>	<p>Хэрэгжүүлсэн хөтөлбөрийн тоо</p>	<p>4</p>	<p>Их сургуулийн захирлын 2022 оны А/660 дугаар тушаалаар “Дотоод хэргийн их сургуулийн багш, албан хаагчдыг өндөр насны болон цэргийн байнгын тэтгэвэрт гарахад бэлтгэх хөтөлбөр”-ийг батлуулан,</p>	<p>100%</p>

				Их сургуулиас 2023 онд тэтгэвэрт гарах албан хаагчдад зориулсан 6 удаагийн сургалтыг зохион байгуулсан.	
	2.4. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагын удирдах, гүйцэтгэх албан тушаалтны ур чадвар, мэдлэгийг дээшлүүлэх, тодорхой чиглэлээр мэргэшүүлэх сургалтын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.	Хөтөлбөрт хамрагдсан суралцагчдын тоо	150	Их сургуулийн захирлын 2022 оны А/521 дүгээр тушаалаар Зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтанд зориулсан сургалтын хөтөлбөр боловсруулах ажлын хэсгийг байгуулан, хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэн ажилласан. Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг зөрчилтэй тэмцэх, мэдлэг чадварыг эзэмшүүлэх чиглэлээр нийт 30 гаруй удаагийн сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор 5,000 гаруй албан хаагч, сонсогч, оюутан, сурагч, иргэнийг хамруулсан.	100%
ХҮНИЙ НӨӨЦИЙГ ХӨГЖҮҮЛЭХ	2.5. Их сургуулийн албан хаагч, ажилтны нийгмийн баталгааг хангах хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.	Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	100	Их сургуулийн захирлын 2022 оны А/112 дугаар тушаалаар Албан хаагч, ажилтны нийгмийн баталгааг хангах хөтөлбөр /2022-2024 он/-ийг шинэчлэн баталсан. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг жил бүр гарган хэрэгжилтийг ханган ажилласан бөгөөд хэрэгжилтийн хугацаанд албан хаагч, ажилтан, сонсогч, суралцагчдын ажиллаж суралцах таатай орчин нөхцлийг бүрдүүлэх, тэдний хүүхдийг цэцэрлэгт хамруулах, тусламж, дэмжлэг олгох ажлыг үе шаттайгаар зохион байгуулан ажилласан.	100%
	2.6. Их сургуулийн албан хаагч, ажилтныг хөгжүүлэх хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.	Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	100	Их сургуулийн захирлын 2022 оны А/112 дугаар тушаалаар баталсан “Дотоод хэргийн их сургуулийн албан хаагч, ажилтны сургалтын хөтөлбөр /2022-2024 он/-ийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг жил бүр баталж, төрийн албанд анх томилогдсон албан хаагч, ажилтны сургалт, мэргэшүүлэх болон хувь хүний хөгжлийг дэмжих сургалт, удирдах албан тушаалтны сургалт гэсэн 3 төрлөөр нийт 60 удаагийн сургалтыг зохион байгуулж, 100 хувийн биелэлттэй хэрэгжүүлсэн.	100%
	2.7. “Дотоод хэргийн их сургуулийн багшийг хөгжүүлэх хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж, санхүүжилтийг нэмэгдүүлнэ.	Зардлын ДХИС-ийн жилийн төсөвт эзлэх хувь	3	Их сургуулийн захирлын 2021 оны А/264 дүгээр тушаалаар “Багшийн хөгжлийн хөтөлбөр /2021-2025/-ийг шинэчлэн баталж, хөтөлбөрт тусгагдсан ажил, арга хэмжээг жил бүрийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган 2021 онд 97%, 2022 онд 95%, 2023 онд 94%-ийг гүйцэтгэлтэй хэрэгжүүлсэн. Их сургуулийн төсөв 2021 оноос хойш 50 хувиар нэмэгдсэнтэй холбогдуулан сургалт, хичээл үйлдвэрлэлийн зардлын 3 хувийг багшийг хөгжүүлэх чиглэлээр зарцуулж байна.	100%
	2.8. Дотоод хэргийн салбарын албан хаагчдыг гадаад хэлний мэдлэгийг дээшлүүлэх	Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	100	Их сургуулийн захирлын 2021 оны А/420 дугаар тушаалаар Дотоод хэргийн салбарын албан хаагчдыг гадаад хэлний мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр /2021-2024/-ийг баталсан. Хөтөлбөрийг	98%

	хөтөлбөр /2021-2024/-ийг хэрэгжүүлнэ.			хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу нийт 5 зорилтын хүрээнд 24 ажил төлөвлөж, 98 хувьтай хэрэгжүүлсэн.	
ГУРАВ. СУДАЛГААНЫ ИХ СУРГУУЛИЙН ЖИШИГТ НИЙЦСЭН ДЭД БҮТЭЦ, ТЕХНИК, ТЕХНОЛОГИ, ОРЧНЫГ ХӨГЖҮҮЛНЭ.					
ДЭД БҮТЭЦ ХӨГЖҮҮЛЭХ	3.1. Дотоод хэргийн их сургуулийг хотхон хэлбэрээр хөгжүүлэх төсөл хэрэгжүүлнэ. /Биеийн тамир, албаны бэлтгэлийн задгай талбай, Шинжлэх ухаан, инновацийн төв байгуулах, Эрх зүй, нийгмийн ухааны сургууль, Хилийн албаны сургууль, Ахлагчийн сургуулийн хичээлийн байрыг шинэчлэх ажлыг эхлүүлсэн байна./	Шинээр барьсан барилгын тоо	7	Их сургуулийг хотхон хэлбэрээр хөгжүүлэх ажлын хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн яамны дэмжлэгтэйгээр Баянзүрх дүүргийн 8 дугаар хороонд байрлах Хууль зүй, дотоод хэргийн яамны эзэмшилд байсан 26.2 мянган м ² газрыг Нийслэлийн засаг даргын 2022 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн А/566 дугаар шийдвэрээр сургалтын зориулалтаар Их сургуулийн эзэмшилд шилжүүлсний дагуу уг газар дээр баригдах 6 барилга, 1 байгууламжийн Техник, эдийн засгийн үндэслэлийг Монгол Улсын Засгийн газрын 1 тэрбум төгрөгийн санхүүжилтээр хийлгэсэн. Тус газарт 2024 онд орон нутгийн 2.2 тэрбум төгрөгийн төсвийн хөрөнгөөр “Спорт-албаны дадлага сургалтын байгууламж”-ийг барьж, ашиглалтад хүлээн авсан. Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө, Улсын 2025 оны төсвийн төсөлд Хилийн албаны сургууль, Шинжлэх ухаан, инновацийн төв, Танхимын бус сургалт явуулах зохиомол орчин бүхий цогцолбор, Оюутны дотуур байрыг барихтай холбогдуулан танилцуулга, төсвийг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн боловч төсөв шийдэгдээгүй болно.	30.0%
ТЕХНИК, ТЕХНОЛОГИЙГ НЭВТРҮҮЛЭХ	3.2. Их сургуулийн удирдлагын болон сургалт, эрдэм шинжилгээний үйл ажиллагаанд программ хангамжийг нэвтрүүлнэ.	Нэмж нэвтрүүлсэн программын тоо	2	“Цахим монгол хөтөлбөр”-ийн хүрээнд программ хангамжуудыг нэгтгэх зорилгоор удирдлага мэдээллийн нэгдсэн систем “Эйбл”-ийг Их сургуульд 2023 оноос нэвтрүүлэн баримт бичгийн урсгалыг бүрэн цахимжуулсан. Их сургуулийн сургалт, элсэлтийн программ хангамжийг шинэчлэх багш, оюутны цахим хуудсыг хэрэглээнд нэвтрүүлж, 2024 оноос Сургалт, удирдлагын систем /Sis/-ийг нэвтрүүлсэн. “Koha” цахим номын сан программ хангамжийг 2023 онд ашиглалтад оруулж, сонсогч, суралцагчдын сонин, сэтгүүл, ном, магистр, докторын ажлыг унших боломжтойгоор байршуулж тус тус ашиглаж байна.	100%
ОРЧНЫГ САЙЖРУУЛАХ	3.3. Олон улсын стандартад нийцсэн лабораторийн тоног төхөөрөмжөөр тоногдсон орчин үеийн судалгааны шаардлагад нийцсэн магадлан итгэмжлэгдсэн лаборатори байгуулна.	Магадлан итгэмжлүүлсэн лабораторын тоо	2	Шинжлэн магадлах ухааны сургуулийн “Мөр судлалын лаборатори” болон “Бичиг баримт судлалын лаборатори”-д олон улсын ISO/IEC 17025:2017 “Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхид тавих ерөнхий шаардлага” стандартыг нэвтрүүлэх ажлыг зохион байгуулж, стандартын шаардлагыг хангуулан, тус 2 лабораторид итгэмжлэл хийлгэхээр “Үндэсний итгэмжлэлийн төв”-д албан хүсэлт илгээсэн. Мөн Шинжлэн магадлах ухааны сургуулийн “Бичиг баримт судлалын лаборатори”, “Мөр судлалын лаборатори”-уудын үйл ажиллагаанд олон улсын ISO/IEC17025:2017 "Сорилтын болон шалгалт	90%

				тохируулгын лабораторийн чадавхид тавих ерөнхий шаардлага" стандартыг нэвтрүүлэх ажлын хүрээнд Их сургуулийн нийт 32 албан хаагчийг "СЭД ЭЭЛ" ХХК-тай хамтран "MiND Set" сургах хөтөлбөрийн "AUDiT MiND" тусгай хөтөлбөрийн сургалтад хамруулж, гэрчилгээ гардуулсан.	
ДӨРӨВ. НИЙГМИЙН БОЛОН ЗАХИАЛАГЧ БАЙГУУЛЛАГЫН ШААРДЛАГЫГ ХАНГАСАН, ШИНЖЛЭХ УХААНЧ ХАНДЛАГАТАЙ, ӨРСӨЛДӨХ, ХӨРВӨХ ЧАДВАРТАЙ ИРГЭНИЙГ БЭЛТГЭНЭ.					
СУРГАЛТЫН ЧАНАРЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ	4.1. "Шинжлэн магадлахуйн институтийг судалгааны сургуулийн загвараар хөгжүүлэх хөтөлбөр" боловсруулж, хэрэгжүүлнэ. /БНЭУ-ын Шинжлэн магадлах ухааны үндэсний их сургуультай хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлэх, лаборатори байгуулах/	Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	100	Их сургуулийн захирлын 2021 оны А/420 дугаар тушаалаар "Шинжлэн магадлахуйн институтийг судалгааны сургуулийн загвараар хөгжүүлэх хөтөлбөр"-ийг баталж, нийт 10 зорилтын хүрээнд 32 ажил, арга хэмжээг төлөвлөн 97.43% хэрэгжүүлсэн. БНЭУ-ын Шинжлэн магадлах ухааны үндэсний их сургуультай хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор БНЭУ-аас Монгол Улсад суух элчин сайд Ноён М.П.Сингхтэй 2 удаагийн албан уулзалт зохион байгуулж, Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатараас БНЭУ-ын Дотоод хэргийн сайд Амит Шан-д 2022 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн 1/5059 дугаар албан бичгээр БНЭУ-ын Шинжлэн магадлах ухааны үндэсний их сургуультай кибер аюулгүй байдлын чиглэлээр хамтран сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх, Монгол Улсад кибер аюулгүй байдлын лаборатори байгуулах саналыг хүргүүлсэн. Монгол Улсаас БНЭУ-д суугаа элчин сайдын яамаар уламжлуулан /2024 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн е/05/24/ дугаар албан бичгээр/ БНЭУ-ын Шинжлэн магадлах ухааны үндэсний их сургуулиас Монгол Улсад салбар сургууль байгуулах боломжтой талаар санал ирүүлсэн байна. Мөн Их сургуулийн захирал, Шинжлэн магадлахуйн институтын захирал, Гадаад харилцаа, хамтын ажиллагааны албаны дарга нар Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Үндэсний шинжлэн магадлах ухааны их сургуульд албан томилолтоор 2022 оны 11 дүгээр сарын 16-ны өдрөөс 18-ны өдрүүдэд ажиллаж, кибер аюулгүй байдлын чиглэлээр хамтран ажиллах саналыг харилцан тохиролцсон. Үүний үр дүнд БНЭУ-ын Засгийн газрын тэтгэлэг /ICCR/-ийн хүрээнд 2023 оноос эхлэн "Кибер аюулгүй байдал", "Шинжлэн магадлахуй" хөтөлбөрт 15 сонсгоч суралцагч хамрагдсан.	97.4%
	4.2. Магистр, докторын сургалтыг өдөр, эчнээ хэлбэрээр зохион байгуулж, шинжлэн ухаан, инноваци, судалгааны чиглэлээр	Сургалтын хөтөлбөрт элсэгчдийн тоо	20	Их сургууль нь магистрын 10, докторын 7 хөтөлбөр хэрэгжүүлж, сургалтыг өдөр, эчнээ хэлбэрээр зохион байгуулан, 2021-2024 оны оны хичээлийн жилд магистрын сургалтад 438, докторын сургалтад 155 суралцагчийг элсүүлэн суралцуулсан. Их сургуулийг түшиглэсэн докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн хурлаар 2021-2024 онд нийт	100%

	ажиллах хүний нөөцийг нэмэгдүүлнэ.			67 горилогч докторын зэрэг хамгаалсны 35 нь тус Их сургуулийн албан хаагч байна. Мөн Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2020 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн А/109 дүгээр тушаалаар баталсан Дотоод хэргийн их сургуулийн “Докторын хөтөлбөрт өдрөөр суралцагч элсүүлэх журам”-ыг мөрдлөг болгон нийт 15 суралцагч докторын хөтөлбөрт суралцаж, Эрдэм шинжилгээний хүрээлэнг түшиглэн эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг гүйцэтгэж, 10 суралцагч докторын зэрэг хамгаалсан.	
	4.3. Докторын дараах судалгааны хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.	Хөтөлбөрт хамрагдсан эрдэмтдийн тоо	5	Гадаад, дотоодын ижил төстэй их, дээд сургуулиудын докторын дараах судалгааны хөтөлбөр хэрэгжүүлж байгаа туршлагыг судалж, Их сургуулийн захирлын 2024 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн “Хөтөлбөр боловсруулах тухай” А/413 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулагдаж, хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж батлуулсан. Уг хөтөлбөрийн хүрээнд Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Хилийн аюулгүй байдал судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, хурандаа Ц.Ганболд Цэргийн шинжлэх ухааны доктор хамгаалахаар судалгааны ажлыг 60 хувьтай гүйцэтгэж, Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн Эрдмийн зөвлөлийн хуралдаанд хэлэлцүүлэхэд бэлэн болсон. Их сургуулийн эрдэмтдээс Ч.Нямсүрэн, Д.Зүмбэрэлхам, Р.Баярмагнай нарын Шинжлэн ухааны докторын судалгааны ажлын материалыг Шинжлэх ухааны академид хүргүүлсэн.	90%
	4.4. Нийгмийн эрэлт хэрэгцээнд нийцсэн бакалавр, магистр, докторын сургалтын хөтөлбөрийг шинээр нээх, хөтөлбөр хэрэгжүүлэх нэгж байгуулах ажлыг зохион байгуулна. /Тусгай хүчний, Мөрдөх албаны сургууль гм /	Шинээр нээсэн хөтөлбөрийн тоо	3	“Албаны сэтгэл судлал”, “Экологийн аюулгүй байдал”, “Шүүхийн шийдвэр гүйцэтгэл” 2 жилийн хөтөлбөр, “Кибер гэмт хэрэг судлал”, “Экологийн аюулгүй байдал”, “Хилийн инженер, техникийн ашиглалт”, “Дотоодын цэрэг судлал” 4 жилийн хөтөлбөр, “Шүүхийн шийдвэр гүйцэтгэл” магистр, докторын хөтөлбөр зэрэг нийт 9 хичээлийн хөтөлбөрийг батлуулж, сургалтыг явуулж байна. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны А/402 дугаар тушаалаар Биеийн тамир, албаны бэлтгэлийн институтийг байгуулсан.	100%
	4.5. Нутгийн өөрөө удирдах болон төрийн захиргааны байгууллагын удирдах ажилтнуудад зориулсан Хууль сахиулах удирдлагын менежментийн мэргэшүүлэх сургалтын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.	Хөтөлбөрт хамрагдсан суралцагчдын тоо	150	Их сургуулийн захирлын 2022 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн А/640 дүгээр “Сургалт зохион байгуулах тухай” тушаалаар Нутгийн өөрөө удирдах болон төрийн захиргааны байгууллагын удирдах албан тушаалтнуудад зориулсан “Хууль сахиулах удирдлага” мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрийг баталж, 2022 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр Баянзүрх дүүргийн төрийн захиргааны байгууллагын 17 удирдах ажилтанд сургалтыг зохион байгуулсан. Нутгийн өөрөө удирдах болон төрийн захиргааны байгууллагын удирдах ажилтнуудад зориулсан “Хууль сахиулах удирдлага”	100%

				мэргэшүүлэх сургалтыг 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр цахимаар зохион байгуулж, 150 албан хаагчийг хамруулсан.	
	4.6. Цахим боловсролыг дэмжих хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ.	Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	100	Их сургуулийн захирлын 2022 оны “Хөтөлбөр батлах тухай” А/246 дугаар тушаалаар “Цахим боловсролыг дэмжих хөтөлбөр 2022-2025”-ийг баталж, хөтөлбөр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг жил бүр гарган хэрэгжүүлж, 2022-2024 онд 38 ажил, арга хэмжээг зохион байгуулан 80 хувийн хэрэгжилттэй ажилласан.	80%
	4.7. Сургалтын хөтөлбөрт үндэсний магадлан итгэмжлэл хийлгэнэ.	Магадлан итгэмжлүүлсэн хөтөлбөрийн тоо	18	Дотоод хэргийн их сургууль бакалаврын 8, магистрын 9, докторын 1 хөтөлбөр, нийт 18 хөтөлбөрийг үндэсний хэмжээнд магадлан итгэмжлүүлсэн.	100%
	4.8. Сургалтын хөтөлбөрийг олон улсад магадлан итгэмжлүүлнэ.	Магадлан итгэмжлүүлсэн хөтөлбөрийн тоо	1	Их сургуулийн “Эрх зүй”, “Онцгой байдал-Гамшиг судлал” бакалаврын хөтөлбөрт олон улсын хамтарсан магадлан итгэмжлэл хийлгүүлэх албан хүсэлтийг Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлд 2024 оны 03 дугаар сарын 12-ны өдөр хүргүүлсэн. Албан хүсэлтийн дагуу Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлөөс гадаадын хамтран ажилладаг магадлан итгэмжлэл, чанарын баталгаажуулалтын дараах байгууллагуудтай холбогдон хамтарсан магадлан итгэмжлэл хийх санал тавьсан. Үүнд: - Казакстаны IAAR - Германы ACQUIN - Германы ASIIN Дээрх байгууллагуудаас ХБНГУ-ын “ACQUIN” чанарын баталгаажуулалтын байгууллага дээрх 2 хөтөлбөрт хамтарсан магадлан итгэмжлэлийг кластраар хийх боломжтой тухай хариуг 2024 оны 10 дугаар сарын 23-ны өдөр ирүүлсний дагуу Их сургуулийн захирлын 2024 оны А/536, А/537 дугаар тушаалаар “Өөрийн үнэлгээний тайлан боловсруулах ажлын хэсэг”-ийг байгуулж, 3 талт хамтарсан гэрээг байгуулаад байна.	30%
	4.9. Сургууль хөгжүүлэх сан байгуулна.	Сангийн тоо	1	Их сургуулийн захирлын 2021 оны А/272 дугаар тушаалаар Дотоод хэргийн их сургуулийн үйл ажиллагааг хөгжүүлэх, хэтийн зорилгыг биелүүлэх зорилгоор “Сургууль хөгжүүлэх сан”-г байгуулж, ажиллах журмыг баталсан.	100%
СУРАЛЦАГЧИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ	4.10. Суралцагчийн хөгжлийг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлнэ.	Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	100	Их сургуулийн захирлын 2022 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн А/382 дугаар “Хөтөлбөр батлах тухай” тушаалаар “Суралцагчийн хөгжлийг дэмжих хөтөлбөр 2022-2025”-ийг баталсан. Хөтөлбөрийн хэрэгжилтийн хугацаанд 28 ажил арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн 86%-ийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлсэн.	86%
	4.11. Суралцагчийн бие бялдарын хөгжлийн түвшинг	Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	100	Их сургуулийн захирлын 2022 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн А/382 дугаар “Хөтөлбөр батлах тухай” тушаалаар Суралцагчийн бие бялдарын хөгжлийн түвшинг дээшлүүлэх хөтөлбөр 2022-2025”-ийг	100%

	дээшлүүлэх хөтөлбөр хэрэгжүүлнэ.			баталж, 8 чиглэлээр үйл ажиллагааг төлөвлөн 100 хувийн биелэлттэй хэрэгжүүлсэн.	
ТАВ. АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЛБАРЫН ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ХӨГЖИЛД ОРУУЛАХ ХУВЬ НЭМРИЙГ НЭМЭГДҮҮЛНЭ.					
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, ТУРШИЛТ, ЗОХИОН БҮТЭЭХ АЖЛЫН ЧАНАРЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ	5.1. Дотоод хэргийн их сургуулийн шинжлэх ухаан, инновацийн хөгжлийн хөтөлбөр /2021-2024/-ийг хэрэгжүүлнэ.	Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	100	Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны А/150 дугаар тушаалаар баталсан “Дотоод хэргийн их сургуулийн 2021-2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө”-нд нийцүүлэн “Дотоод хэргийн их сургуулийн шинжлэх ухаан, инновацын хөгжлийн хөтөлбөр /2021-2024/-ийг баталж, 85%-ийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлсэн. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний дагуу дараах ажил, арга хэмжээг зохион байгуулсан. Тухайлбал: 1. 2022,2023 онд Их сургуулийн захирлын тушаалаар “Инновацийн шилдэг төсөл, бүтээл шалгаруулах уралдаан”-ыг 2 үе шаттай зохион байгуулж, шалгаруулсан. 2. “Гутлын мөр болон тээврийн хэрэгслийн мөрийг бэхжүүлж авахад ашиглах хашлага” бүтээлд Монгол Улсын Оюуны өмчийн газрын даргын 2022 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн А/39 тоот тушаалаар 20-0003429 улсын бүртгэлийн дугаартай ашигтай загварын гэрчилгээ авсан. 3. “Давхар эргэх байнгын шат” төслийг үйлдвэрлэлд нэвтрүүлж төв, орон нутгийн онцгой байдлын газар, хэлтсийн гал унтраах, аврах ангид хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулж, Оюуны өмчийн газарт ашигтай загварын гэрчилгээг авсан.	85%
	5.2. Эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлыг төсөл хэлбэрээр хэрэгжүүлэх тогтолцоог төлөвшүүлнэ.	Төсөл хэлбэрээр хэрэгжүүлсэн судалгааны ажлын тоо	12	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хугацаанд 10 судалгааны ажлыг төсөл хэлбэрээр хэрэгжүүлсэн байна. Тухайлбал: Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын албаны захиалгаар “Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном-2021” бүтээлийг эрхлэн гаргах төслийг амжилттай хэрэгжүүлж, 2022, 2023 онд тус тус эрхлэн гаргаж, захиалагч байгууллагад хүлээлгэн өгсөн. 2022 онд Эрдэм шинжилгээний хүрээлэн “Мөрдөн шалгах ажиллагаанд ашиглах криминалистикийн техник, хэрэгслийг боловсронгуй болгох туршилт, судалгаа”; Азийн хөгжлийн банк, Хууль зүй, дотоод хэргийн яамтай хамтран 2022 онд хэрэгжүүлсэн “Хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх төсөл”-ийн хүрээнд “Хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг үйлдэгдсэн гэр бүлийн хүчирхийллийн криминологи судалгаа” сэдэвт төсөл; Шинжлэн магадлахуйн институтын Криминалистикийн шинжилгээний тэнхим "Адууны туурай криминалистикийн адилтгал болон онош зүйн шинжилгээний объект болохыг тогтоох" шинжлэх ухаан, технологийн захиалгат төсөл;	90%

				Цагдаагийн сургууль Азийн сантай хамтарсан “Хууль бус уул уурхайн үйл ажиллагаатай тэмцэх алба хаагчийн чадавхыг бэхжүүлэх” захиалгат төсөл; 2024 оноос НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Хууль зүй, дотоод хэргийн яамтай хамтран “Монгол Улсад хууль сахиулах ажиллагаанд хүний эрх, жендерийн тэгш байдлыг дээшлүүлэх нь” төслийг тус тус хэрэгжүүлж байна.	
	5.3. Олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн, мэргэжлийн түвшинд хянагддаг, нэр хүнд бүхий сэтгүүлд өгүүлэл нийтлүүлнэ.	Сэтгүүлд нийтлүүлсэн өгүүллийн тоо	16	Давхардсан тоогоор Их сургуулийн 40 профессор багш, судлаач олон улсын хянан магадлагаа бүхий эрдэм шинжилгээний сэтгүүлд 19 эрдэм шинжилгээний өгүүллийг нийтлүүлсэн байна.	100%
	5.4. Эрдэм шинжилгээний нэг сэдэвт бүтээл, сурах бичиг, гарын авлагын чанарыг сайжруулж, тоог нэмэгдүүлнэ.	Нэмж хэвлэгдсэн бүтээлийн тоо	20	Их сургуулийн профессор, багш, судлаачид 2021 онд нэг сэдэвт бүтээл 8, гарын авлага 10, сурах бичиг 6, нийт 24 бүтээл, 2022 онд нэг сэдэвт бүтээл 9, гарын авлага 6, сурах бичиг 4, нийт 19 бүтээл, 2023 онд нэг сэдэвт бүтээл 14, гарын авлага 14, сурах бичиг 5, нийт 33 бүтээл, 2024 онд нэг сэдэвт бүтээл 7, гарын авлага 9, сурах бичиг 1, нийт 17 бүтээл эрхлэн гаргаж, нийтийн хүртээл болгосон байна. Мөн Их сургуулийн 90 жилийн ойг тохиолдуулан “Дотоод хэргийн их сургуулийн профессорын эрдмийн дээжис” 120 ботийг эрхлэн гаргаж, нийтийн хүртээл болгосон.	100%
	5.5. Эрдэм шинжилгээ, туршилт, судалгааны ажлын үр дүнд оюуны өмчийн эрхийн гэрчилгээгээр баталгаажуулах ажлын зохион байгуулалтыг сайжруулах	Гэрчилгээний тоо	40	Их сургуулийн багш, албан хаагчид Оюуны өмчийн газраас 2021 онд зохиогчийн эрхийн гэрчилгээ 5, барааны тэмдэг 1, 2022 онд зохиогчийн эрхийн гэрчилгээ 4, ашигтай загварын гэрчилгээ 2, 2023 онд зохиогчийн эрхийн гэрчилгээ 11, 2024 онд зохиогчийн эрхийн гэрчилгээ 5, ашигтай загварын гэрчилгээ 1, нийт зохиогчийн эрхийн гэрчилгээ 25, ашигтай загварын гэрчилгээ 3, барааны тэмдэг 1-ийг тус тус авсан байна.	72.5%
	5.6. Эрдэм шинжилгээ, туршилт, судалгааны ажлын үр дүнг хэрэглээнд нэвтрүүлэх тогтолцоог бүрдүүлнэ.	Практикт нэвтрүүлсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний тоо	8	Хэрэгжилтийн хугацаанд нийт 8 эрдэм шинжилгээ, туршилт судалгааны ажлыг практикт нэвтрүүлэн, үйл ажиллагааг явуулж байна. Үүнд: - 2021 онд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын албаны захиалгаар “Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном”-ыг эрхлэн гаргаж, цагдаагийн байгууллагын гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын гол судлагдахуун болсон. - 2022 онд “Хоригдлыг цахим сургалтад хамруулах арга зам” инновацын судалгааны үр дүнгээр сургалтыг цахимаар явуулах хөтөлбөр боловсруулж, Хорих 421 дүгээр нээлттэй хорих ангид туршилтыг эхлүүлж, үйл ажиллагаанд нэвтрүүлсэн. - Хилийн болон хил орчмын бүс нутгийн маргаантай асуудлуудад тодорхой баримт мэдээлэл болох зорилгоор ОХУ-ын Бүгд	100%

				<p>Найрамдах Тува Улсын Кызыл хот дахь Үндэсний төв архивд БНМАУ, ЗСБНУ-ын хооронд 1958 онд байгуулсан хилийн гэрээнд дүн шинжилгээг хийж, судалгааны бүтээлийг 2022 оны 06 дугаар сард хэвлүүлж, нийтийн хүртээл болгосон.</p> <ul style="list-style-type: none">- “Мөрдөн шалгах ажиллагаанд ашиглах криминалистикийн техник, хэрэгслийг боловсронгуй болгох туршилт, судалгаа”-ны ажлын хүрээнд хэргийн газрын үзлэгийн төрөл бүрийн цүнхийг иж бүрдлийн хамт зохион бүтээж, Хил хамгаалах ерөнхий газарт 27, Дотоод хэргийн их сургуулийн Шинжлэн магадлахуйн институтэд 1, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнд 2, Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуульд 1, нийт 31 ширхгийг туршилтаар ашиглуулж, хэрэглээнд нэвтрүүлсэн. Нийслэлийн Онцгой байдлын газрын галын шинжээч нартай уулзалт хийж, галын голомтод үүрэг гүйцэтгэх шинжээч нарын ажиллах нөхцөлийг сайжруулах зорилгоор Галын үзлэгийн иж бүрэн цүнхийг шинээр хийж, хүлээлгэн өгсөн.- "Адууны туурай криминалистикийн адилтгал болон онош зүйн шинжилгээний объект болохыг тогтоох" төслийн хүрээнд “Адууны туурай криминалистикийн адилтгал болон онош зүйн шинжилгээ” бүтээлийг хэвлүүлж, судалгааны эргэлтэд оруулсан.- Азийн хөгжлийн банк, Хууль зүй, дотоод хэргийн яамтай хамтран 2022 онд хэрэгжүүлсэн “Хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх төсөл”-ийн хүрээнд “Хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг үйлдэгдсэн гэр бүлийн хүчирхийллийн криминологи судалгаа” сэдэвт төслийг хэрэгжүүлснээр цагдаагийн байгууллагын гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил явуулахад гол судлагдахуун болсон.- 2023 онд “Дотоодын цэргийн чиг үүрэг, үйл ажиллагаа, эрх зүйн байдал” сэдэвт судалгааны ажлыг гүйцэтгэж, дотоодын цэргийн байгууллагын хүний нөөцийн үйл ажиллагааны онолын үндсийг тодорхойлж, дотоодын цэргийн байгууллагын хүний нөөцийн бодлогын өнөөгийн байдал, хэрэгжилт, дотоодын цэргийн байгууллагын алба хаагчдын эрх зүйн байдалд дүн шинжилгээ хийж, санал, зөвлөмж боловсруулсан. Энэхүү судалгааны үр дүнд “Дотоодын цэргийн байгууллагын хүний нөөцийн бодлогын баримт бичиг”-ийг боловсруулсан.- 2024 оноос НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Хууль зүй, дотоод хэргийн яамтай хамтран “Монгол Улсад хууль сахиулах ажиллагаанд хүний эрх, жендерийн тэгш байдлыг дээшлүүлэх нь” төслийг хэрэгжүүлж, хичээлийн хөтөлбөрүүдэд үнэлгээ хийж, хүний эрхэд суурилсан сургалтын хөтөлбөрүүдийг боловсруулж, танхимуудыг тохижуулан үйл ажиллагааг явуулж байна.	
--	--	--	--	--	--

	<p>5.7. Дотоодын эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагатай хамтын ажиллагааг өргөжүүлэн, хамтарсан судалгааны ажлыг хийж гүйцэтгэнэ.</p>	<p>Хамтын ажиллагаатай байгууллагыг нэмэгдүүлсэн тоо</p>	<p>8</p>	<p>Дотоод хэргийн их сургуулиас Монгол-Оросын хувь нийлүүлсэн нийгэмлэг “Улаанбаатар төмөр зам”, Монголын Улаан загалмайн нийгэмлэг, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Монгол банк, Отгонтэнгэр их сургууль, Монгол Улсын боловсролын их сургууль, Хөдөө аж ахуйн их сургууль, Шинжлэх ухаан технологийн их сургууль, Ботаникийн цэцэрлэгт хүрээлэн, Монголын Жюю Жицү Холбоо, Үндэсний цэцэрлэгт хүрээлэн ОНӨТҮГ, Монголын хуульчдын холбоо, Хүрээ мэдээлэл, технологийн дээд сургууль, Монгол Улсын гаалийн ерөнхий газар, Улсын ерөнхий прокурорын дэргэдэх сургалт, судалгааны хүрээлэн зэрэг 15 байгууллагатай хамтран ажиллах гэрээ, санамж бичгийг байгуулан, сургалт, эрдэм шинжилгээний чиглэлээр хамтран ажиллаж байна.</p> <p>Мөн Цагдаагийн ерөнхий газрын захиалгаар 2023 онд “Цахим гэмт хэргийн шалтгаан нөхцөл, урьдчилан сэргийлэх арга зам” сэдэвт судалгааны ажил, “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын сургалт, судалгааны ажлыг сайжруулах хэрэгцээ, шаардлага” сэдэвт судалгааны ажил, “Залилах гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, урьдчилан сэргийлэх арга зам” сэдэвт судалгааны ажил, “Цагдаагийн алба хаагчийн үйлдсэн гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, урьдчилан сэргийлэх арга зам” сэдэвт судалгааны ажил, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын захиалгаар “Хоригдлыг цахим сургалтад хамруулах арга зам” инновацын судалгаа, “Ковид-19” цар тахлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ” судалгааны ажлыг Монголын Улаан загалмай нийгэмлэг, Гамшиг судлалын үндэсний хүрээлэнтэй тус тус хамтран гүйцэтгэсэн бөгөөд судалгааны хүрээнд ХЗДХЯ, БШУЯ, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын алба, Стратеги судалгааны хүрээлэн, ХЭҮК, ЦЕГ, ШШГЕГ, ОБЕГ, ХХЕГ, Хууль зүйн үндэсний хүрээлэн, ГХУСАЗЗ-ын Ажлын алба зэрэг байгууллагатай тогтмол хамтран ажиллаж байна.</p>	<p>100%</p>
	<p>5.8. Дотоод хэргийн их сургуулиас эрхлэн гаргадаг сэтгүүлүүдийн чансааг тогтоож, "Хууль сахиулахуй" сэтгүүлийг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн сэтгүүл болгох ажлыг зохион байгуулна.</p>	<p>Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн сэтгүүл болоход шат ахисан байна. (ISSN, EISSN, DOI г.м дугаар авсан эсэх)</p>	<p>1</p>	<p>Дотоод хэргийн их сургуулийн бүрэлдэхүүн сургууль, Эрдэм шинжилгээний хүрээлэнгээс Хууль сахиулахуй, Гэмт явдалтай тэмцэх асуудал, Хууль сахиулахуйн удирдлага, Цагдаа судлал, Хил судлал, Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлал, Гамшигийн эрсдэл судлал зэрэг онол, арга зүйн сэтгүүлийг тогтмол эрхлэн гаргаж байна. Эдгээр сэтгүүлээс 2022 онд “Хууль сахиулахуй” онол, арга зүйн сэтгүүл нь Шинжлэх ухааны академийн бага чуулганы шийдвэрээр мэргэжлийн сэтгүүлийн жагсаалтад бүртгэгдсэнээс гадна “Хууль сахиулахуй”, “Гэмт явдалтай тэмцэх асуудал”, “Хууль сахиулахуйн удирдлага”, “Гамшигийн эрсдэл судлал” сэтгүүлд олон улсын ISSN дугаар авсан.</p>	<p>100%</p>

				<p>“Хууль сахиулахуй” онол, арга зүйн сэтгүүлийг 2024 оноос олон улсад бүртгэлтэй сэтгүүл болгох ажлын хүрээнд Mongolia JOL буюу Монгол Улсын Шинжлэх ухааны академи болон олон улсын INASP байгууллагын хамтарсан төслийн багт сэтгүүлийн танилцуулга, холбогдох материалыг хүргүүлэн, зөвлөмж авч, олон улсын хянан магадлагаа бүхий эрдэм шинжилгээний бүтээлийн сангаас сэтгүүлд тавигдах шалгуур шаардлагыг судлан дараах ажлыг хийсэн. Үүнд:</p> <p>-Их сургуулиас эрхлэн гаргадаг онол, арга зүйн 7 сэтгүүлийн бүтээлийн чанарыг сайжруулах “Онол, арга зүйн сэтгүүлийг эрхлэн гаргах, түгээх журам” (Ж.204-05)-ыг шинэчлэн боловсруулж батлуулсан.</p> <p>-Бүтээлийн чанарыг нэмэгдүүлэх, хүний эрхийг хангасан, ёс зүйтэй судалгааны ажлыг нийтлэх бодлогыг удирдлага болгон бүтээлийн хуулбарлалтыг шалган, давхар нууцлалтай хянан магадлуулж байна.</p> <p>-Сэтгүүлийн 2024 оны №3 дугаараас эхлэн буюу "Creative Commons Attribution License (CC-BY 4.0)" буюу "CC-BY 4.0" бүтээлийг ашиглах, эзэмших эрхийг мэдээллийг тодорхой болгосон.</p> <p>-Сэтгүүлийг DOI дугаартай болгох ажлын хүрээнд цахим сан үүсгэх талаар удирдлагад танилцуулан “Хууль сахиулахуй” эрдэм шинжилгээний сэтгүүлийн цахим хуудсыг хийлгэхээр төлөвлөн ажиллаж байна.</p>	
5.9. Гэмт хэрэгтэй тэмцэх, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гамшигтай тэмцэх, хилийн аюулгүй байдлыг хангах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, шинжлэн магадлах зэрэг дотоод аюулгүй байдлын чиглэлээр хэрэгжүүлэх төсөл, гарааны бизнесийг дэмжих хөрөнгө оруулалтын тусгай сан байгуулна.	Байгуулсан сангийн тоо	1	<p>Гэмт хэрэгтэй тэмцэх, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гамшигтай тэмцэх, хилийн аюулгүй байдлыг хангах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, шинжлэн магадлах зэрэг дотоод аюулгүй байдлын чиглэлээр хэрэгжүүлэх төсөл, гарааны бизнесийг дэмжих хөрөнгө оруулалтын тусгай сан байгуулах талаар судалгаа хийсэн. Их сургуулийн захирлын 2021 оны А/272 дугаар тушаалаар Дотоод хэргийн их сургуулийн үйл ажиллагааг хөгжүүлэх, хэтийн зорилгыг биелүүлэх зорилгоор “Сургууль хөгжүүлэх сан”-г байгуулж, ажиллах журмыг баталсан. Тус сангийн дансыг 2022 онд Сангийн яамны төрийн санд нээлгэж, холбогдох журмын дагуу эрдэм шинжилгээ, судалгааны ажил, төсөл, хөтөлбөр, гарааны бизнесийг хандивлагчдын хөрөнгөөр санхүүжүүлэн ажиллаж байна.</p>	100%	
5.10. Их сургуулийн шинжлэх ухаан, технологийн хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлэх зорилгоор шинжлэх ухааны цэргийн нэгж байгуулах асуудлыг судалж шийдвэрлүүлнэ.	Байгуулсан шинжлэх ухааны цэргийн салаа	45	<p>Их сургуулийн шинжлэх ухаан, хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлэх зорилгоор Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2020 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн А/109 дүгээр тушаалаар Дотоод хэргийн их сургуулийн “Докторын хөтөлбөрт өдрөөр суралцагч элсүүлэх журам”-ыг баталж, 2020-2021 оны хичээлийн жилд 7, 2022-2023 оны хичээлийн жилд 1, 2023-2024 оны хичээлийн жилд 3, 2024-2025 оны хичээлийн жилд 4, нийт 15 суралцагч докторын хөтөлбөрт өдрийн</p>	55.5%	

				хэлбэрээр суралцаж, Эрдэм шинжилгээний хүрээлэнг түшиглэн эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг гүйцэтгэж, 10 суралцагч докторын зэрэг хамгаалсан.	
<p>Стратегийн 1 дүгээр зорилтын хүрээнд 14 ажил, арга хэмжээний биелэлт 97.9% Стратегийн 2 дугаар зорилтын хүрээнд 8 ажил, арга хэмжээний биелэлт 100.0% Стратегийн 3 дугаар зорилтын хүрээнд 3 ажил, арга хэмжээний биелэлт 73.3% Стратегийн 4 дүгээр зорилтын хүрээнд 11 ажил, арга хэмжээний биелэлт 89.3% Стратегийн 5 дугаар зорилтын хүрээнд 10 ажил, арга хэмжээний биелэлт 90% Нийт дундаж: 90.1 хувь "Тодорхой үр дүнд хүрсэн"</p>					

---oOo---

